

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/169 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН УДИРДАМЖ

### НЭГ.ҮНДЭСЛЭЛ:

1.1.“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын зорилт 2.3, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 2.3.1, 2.3.3 болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.4-т “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасны дагуу Аймаг, дүүргүүд орон нутгийн онцлог, өрх, хүн амын тоо, гэр бүлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг байгуулна.

1.2.Төвийг тухайн аймаг, дүүрэг, сумын барилга байгууламж, хүний нөөц, санхүүгийн чадавхад тулгуурлан хүн амын тоо, бүтэц, амьдралын хэв маяг, орон нутгийн хүн амын онцлог, нийгмийн нөхцөл байдал, статистик тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн боломжит үйлчилгээ, хөтөлбөрийг төлөвлөн төр, хувийн хэвшлийн байгууллагын түншлэлээр хамтран ажиллуулна.

### ХОЁР.ЗОРИЛГО:

2.1.“Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв”-ийн үйлчилгээний жишиг загвар боловсруулж, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, шаардагдах зардлын тооцоолол, зөвлөмж гарган Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүлээлгэн өгөх.

### ГУРАВ.ХАМРАХ ХҮРЭЭ:

3.1. 3 аймаг, 2 сум, 1 дүүрэгт

### ДӨРӨВ.ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ:

4.1.Сонгосон аймаг, сум, дүүргийн орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагын судалгааг хийж, 2 сарын хугацаанд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

4.1.1.“Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв”-ийн үйлчилгээний жишиг загвар, төв байгуулах алхамчилсан зураглал боловсруулах;

4.1.2.Сонгосон аймаг дүүргийн онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний санал, зөвлөмж боловсруулах;

4.1.3. Хүний нөөц болон шаардагдах бусад зардлын тооцооллыг гаргах;

### ТАВ.ТАВИГДАХ ШААРДЛАГА:

5.1.Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.1.1.Боловсрол:

5.1.1.1.Хүн ам, гэр бүл, жендер, нийгэм, хууль эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, доктор бол давуу тал болно.

5.1.1.2.Гэр бүл, нийгмийн ажлын чиглэлээр мэргэшсэн.

5.1.2.Туршлага:

5.1.2.1.Гэр бүл, нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйн мэдлэг, туршлагатай.

5.1.2.2.Гэр бүлийн чиглэлээр ажилласан туршлагатай.

5.1.2.3.Гэр бүл, нийгэм, жендер, хүчирхийллийн асуудлаар бодлого, хууль, хөтөлбөр боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай.

- 5.1.2.4.Дээр дурдсан чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
- 5.1.3.Хэлний ур чадвар:
- 5.1.3.1.Англи хэлийг мэргэжлийн чиглэлээр хэрэглэх түвшинд эзэмшсэн.
- 5.1.4.Мэргэжлийн ур чадвар:
- 5.1.4.1.Албан бичиг баримт бичиг боловсруулах;
- 5.1.4.2.Баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоог бие даан хийж дүгнэлт гаргах, холбогдох материалыг бүрдүүлэх;
- 5.1.4.3.Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, удирдан чиглүүлэх;
- 5.1.4.4.Компьютерын хэрэглээний программууд дээр чөлөөтэй ажиллах;
- 5.1.4.5.Богино хугацаанд ачаалалтай, бие даан ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай байх;
- 5.1.4.6.Холбогдох салбарт ашиг сонирхлын зөрчилгүй байх.

#### **ЗУРГАА.ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БҮТЭЭГДЭХҮҮН:**

- 6.1.“Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв”-ийн үйлчилгээний жишиг загвар, төв байгуулах алхамчилсан зураглал;
- 6.2.Сонгосон аймаг дүүргийн онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний санал, зөвлөмж;
- 6.3.Хүний нөөц болон шаардагдах зардлын тооцоолол;
- 6.4.дээрх бүх материалыг хэвлэмэл байдлаар болон файлаар хүлээлгэн өгнө.

#### **ДОЛОО.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ:**

- 7.1.Ажил гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагчаар батлуулна.
- 7.2.ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын дарга, гэр бүлийн асуудал хариуцсан албан хаагчидтай байнга холбоотой ажиллана.
- 7.3.ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын Гэр бул, хүн амын хэлтсийн гэр бүлийн асуудал хариуцсан албан хаагчид ажил гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавина.
- 7.4.Ажлын явцын тайлан болон хүлээлгэн өгөх бүтээгдэхүүнийг төлөвлөгөөний дагуу захиалагч талд танилцуулж, эцэслэн гэрээт хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

#### **НАЙМ.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:**

- 8.1.2025 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 08 дугаар сарын 11-ний өдрийн хооронд 2 сарын хугацаанд ажиллана.
- 8.2.Ажил эхэлсэн өдрөөс Захиалагч байгууллагад нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг бүрэн хүлээлгэн өгсөн ч шаардлагатай үед хамтран ажиллана.

#### **ЕС.ТӨСӨВТ ӨРТӨГ:**

- 9.1. 20,0 (хорин сая) төгрөг.

---Оо---